



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 27

Бор-Өндөр

**ДЭД ХӨТӨЛБӨР БАТЛАХ
ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. “Зөөлөн сэтгэлтэй-Зөв хүмүүжилтэй” хүүхэд дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Тус хөтөлбөрийг холбогдох хууль журмын хүрээнд хэрэгжүүлж ажиллахыг Бор-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж байгаа боловсролын байгууллагын захирал, эрхлэгч нарт болон Засаг дарга П.Чинбатад даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын хороон дарга Ж.Энх-Оргилд үүрэг болгосугай.
4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр тайлагнаж ажиллахыг Засаг дарга П.Чинбатад даалгасугай.

ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ